



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 2/449

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10-ны хооронд "Томуугаас сэргийлье" уриан дор зохион байгуулсугай

2. Улирлын томуугийн эсрэг вакцины хуваарийг нэгдүгээр, вакцин хэрэглэх зааврыг хоёрдугаар, хамралтын мэдээ авах хүснэгт, вакцин хийлгэх зөвшөөрлийн хуудсыг гуравдугаар, А аминдэм түгээх хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


3. Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд нийслэлийн цэцэрлэгийн хүүхдүүд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн хүүхдүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнийг улирлын томуугийн эсрэг вакцины дархлаажуулалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Дархлаажуулалтын 10 хоногийн үед нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар болон амралтын өдрүүдэд ажиллахаар зохицуулалт хийхийг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т даалгасугай.

5. Дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга (Т.Энхзаяа), Эмнэлгийн тусламжийн газрын дарга (Я.Буянжаргал)-д нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141201727

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 22 өдрийн 8/ тушаалын
нэгдүгээр хавсралт 449

Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах улирлын
томуугийн эсрэг вакцины хуваарь

Д/д	Аймаг	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан (Butantan)	Аймгийн төвийн 2-5 хүртэлх насны хүүхдүүд (GC flu)	Жирэмсэн эмэгтэйчүүд (Butantan)	65-аас дээш насны хүмүүс (Butantan)	Архаг хууч өвчтэй хүмүүс (Butantan)	Нийт вакцины тоо
1	Архангай	750	1820	930	2090	170	5,760
2	Баян-Өлгий	850	3460	770	1750	1040	7,870
3	Баянхонгор	950	2760	570	1730	330	6,340
4	Булган	570	900	280	1560	460	3,770
5	Говь-Алтай	700	1420	420	1160	750	4,450
6	Говьсүмбэр	240	1180	130	330	200	2,080
7	Дархан-Уул	630	7100	670	2370	470	11,240
8	Дорноговь	600	2210	350	1280	500	4,940
9	Дорнод	760	4080	400	1670	440	7,350
10	Дундговь	550	1380	260	1230	530	3,950
11	Завхан	790	1270	570	1640	1030	5,300
12	Орхон	560	8290	640	2140	550	12,180
13	Өвөрхангай	860	2740	770	2630	1180	8,180
14	Өмнөговь	550	2470	520	1320	770	5,630
15	Сүхбаатар	570	2070	390	1250	480	4,760
16	Сэлэнгэ	900	1690	530	2360	820	6,300
17	Төв	1050	1400	450	2390	530	5,820
18	Увс	880	2800	470	1450	500	6,100
19	Ховд	800	2750	650	1630	1050	6,880
20	Хөвсгөл	900	3190	930	2730	1210	8,960
21	Хэнтий	740	2050	450	1720	980	5,940
Нийт		15,200	57,030	11,150	36,430	13,990	133,800

Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах улирлын
томуугийн эсрэг вакцины хуваарь


Д/д	Дүүрэг	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан (Butantan)	6 сартайгаас 10 хүртэлх насны хүүхдүүд				Жирэмсэн эмэгтэйчүүд (Butantan)	65-аас дээш нас (Butantan)	Архаг хууч өвчтэй хүмүүс (Butantan)	Тариур (ширхэг)
			0-6-1 нас (GC flu)	2-5 нас (GC flu)	6-9 нас (Butantan)					
1	Сүхбаатар	530	3,280	10,010	14,200	710	2660	570	31,960	
2	Баянгол	540	6,150	18,980	22,140	1390	4980	890	55,070	
3	Баянзүрх	900	9,890	27,130	34,600	3090	9130	1,700	86,440	
4	Чингэлтэй	460	3,670	10,670	14,770	980	3700	720	34,970	
5	Сонгинохайрхан	800	9,230	25,910	31,920	2040	7760	3,310	80,970	
6	Хан-Уул	700	5,200	15,870	19,100	890	1690	420	43,870	
7	Налайх	320	820	2,740	3,920	130	820	80	8,830	
8	Багануур	300	760	1,770	2,760	160	750	220	6,720	
9	Багахангай	30	120	270	410	20	20	40	910	
10	Жаргалант тосгон	40							40	
11	Гачуурт тосгон	20							20	
12	Туул тосгон	30							30	
13	Хонхор тосгон	20							20	
14	Амгалан амаржих газар	200							200	
15	Таны төлөө бид ххк	40							40	
16	Өргөө амаржих	380							380	
17	Хүрээ амаржих	140							140	
18	НЯТТТ 103	360							360	
19	Нийслэлийн шүд эрүү нүүрний эмгэгийн төв	40							40	
20	НЭМГ	40	39,120	113,350	143,820	9,410	31,510	7,950	351,050	
Нийт		5,890								

Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах улирлын
томуугийн эсрэг вакцины хуваарь
/эрүүл мэндийн байгууллага, бусад салбарын байгууллага/

Д/д	Бусад эрүүл мэндийн байгууллага	Вакцинд хамруулах хүний тоо (Butantan)	Тариур (ширхэг)
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	400	400
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	480	480
3	Улсын гуравдугаар төв эмнэлэг	400	400
4	Халдварт өвчин судлалын үндэсний төв	600	600
5	Хавдар судлалын үндэсний төв	450	450
6	Зооноз өвчин судлалын үндэсний төв	70	70
7	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	800	800
8	Батлан хамгаалах хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	240	240
9	Цэргийн төв эмнэлэг	440	440
10	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	30	30
11	Гэмтэл согог судлалын үндэсний төв	240	240
12	АӨСҮТ	100	100
13	СЭМҮТ	320	320
14	Хөдөлмөр аюулгүй байдлын эрүүл мэндийн төв	30	30
15	Геронтологийн үндэсний төв	30	30
16	Эрүүл мэндийн хөгжлийн төв	30	30
17	Нялхсын клиник	80	80
18	Төмөр замын эмнэлэг	160	160
19	Монгол-Японы эмнэлэг	400	400
20	АШУҮИС	700	700
21	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв	70	70
22	Уламжлалт анагаах ухааны корпораци	80	80
23	Эмгэг судлалын төв	20	20
24	Энэрэл эмнэлэг	70	70
25	429-р хорих анги эмнэлэг	170	170
26	Рашаан судлалын үндэсний төв	70	70
27	Сэргээн засах клиникийн эмнэлэг	80	80
28	Эрүүл мэндийн яам	120	120
29	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	100	100
Нийт		6,780	6,780

Д/д	Бусад байгууллага	Вакцинд хамруулах хүний тоо (Butantan)	Тариур (ширхэг)
1	Улсын их хурлын тамгын газар	300	300
2	Онцгой байдлын ерөнхий газар	1,000	1,000
5	Хил хамгаалах ерөнхий газар	500	500
6	Зэвсэгт хүчин, жанжин штаб	1,000	1,000
8	Тагнуулын ерөнхий газар	300	300
9	Цагдаагийн ерөнхий газар	1,430	1,430
4	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	800	800
6	Чингис олон улсын нисэх буудал	90	90
8	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	200	200
9	Төрийн тусгай хамгаалалтын алба	400	400
10	Үндсэн хуулийн цэц	90	90
11	Буянт ухаа дахь гаалийн газар	100	100
12	Гаалийн ерөнхий газар	160	160
13	Сайн дурын дархлаажуулалтын кабинет	11,500	11,500
	Нийт	17,870	17,870

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 22 өдрийн 9/ тушаалын
хоёрдугаар хавсралт 449



Томуугийн эсрэг "GC FLU" вакциныг хэрэглэх заавар

Томуугийн эсрэг "GC FLU" вакцин нь томуугийн вирусийн антигенийг идэвхгүйжүүлж гарган авсан. 2020-2021 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон, магадлан итгэмжлэгдсэн вакцин. Вакцины найрлаганд орсон томуугийн вирусийн дэд хэв шинжийн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Найрлага:

Томуугийн вирусийн дараах гурван дэд хэвшинжийг агуулсан. Үүнд:

А Хүрээ (H1N1)

А Хүрээ (H3N2)

В Хүрээ

Нэмэлтээр тиомерсал, содиум хлорид, потассиум хлорид, дисодиум гидроген фосфат дигидрат, потассиум дигидроген фосфат, тарилгын шингэн агуулсан.

Савлалт:

Нэг хүн тун нь 0,5 мл, Флаконт 10 хүн тунгаар савлагдсан. Вакцин өнгөгүй шингэн суспенз.

Тун ба тарих арга:

Вакциныг булчинд тарина.

- 6 сар-2 насны (35 сар буюу 2 нас 11 сар 29 хоног) хүүхдэд 0,25 мл-ээр 28 хоногийн зайтай 2 удаа тарина.
- 3 настай хүүхэд болон түүнээс дээш насныханд 0.5 мл-ээр нэг удаа тарина.

Эсрэг заалт:

- Вакцины найрлагад орсон бодисуудад өмнө нь анафилаксийн урвал илэрч байсан
- Өндөг, тахианы гаралтай бүтээгдэхүүнүүдэд хэт мэдрэг хариу урвал өгч байсан
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт өгсөн
- Өмнө нь томуугийн вакцин хийлгэснээс хойш 6 сарын дараа Гиллен Барын хам шинж өгч байсан
- Мэдрэлийн үрэвслийн хам шинжийн үед
- Дархлал дутмагшилтай
- Гормон эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс
- Хавдрын эмчилгээний цитостатик эм хэрэглэж буй үед

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын шинжүүд илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд энцефаломиелит, анафилаксийн шок, харшлын урвалууд, татах, мэдрэлийн тогтолцооны ерөнхий болон хэсэг газрын үрэвсэл, амьсгалахад саадтай болох хүнд урвалууд вакцин хийлгэсний дараа 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдгүүд илэрвэл яаралтай эмчид хандах хэрэгтэй.

Анхааруулга:

- 1) Томуугийн вакциныг бусад товлолын вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна
- 2) Тарилгын стандартыг баримтлан ажиллана
- 3) Задалсан вакциныг дараах нөхцлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
 - Вакциныг +2-+8 хэмд хадгалсан;
 - Вакцины шошго арилаагүй;
 - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- 4) Вакцин хийлгэж байгаа хүмүүст тарьсан хэсгийг бохирдуулахгүй байлгах болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандах талаар зөвлөх хэрэгтэй.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйд вакцин хийхийн өмнө заавал эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсэний 4 дэх сараас томуугийн вакцин хийлгэж болно.

Хадгалах тээвэрлэх:

- Вакциныг +2+8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ
- Халууны нөлөөнд орсон эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянана
- Хөлдөөж болохгүй

Хүчинтэй хугацаа: 2021 оны 8-р сарын 6

Үйлдвэрлэгч: Green Cross Corporation, Korea

Томуугийн эсрэг “BUTANTAN FLU” вакциныг хэрэглэх заавар

Томуугийн эсрэг 3 цэнт вакцин нь томуугийн вирусийн антигенийг идэвхгүйжүүлж гарган авсан. 2020-2021 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон, магадлан итгэмжлэгдсэн вакцин. Вакцины найрлагад орсон томуугийн вирусийн дэд хэв шинжийн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

Найрлага:

Нэг хүн тун томуугийн вакцинд томуугийн вирусийн дараах гурван дэд хэвшинжийг агуулсан. Үүнд

А Хүрээ (H1N1)

А Хүрээ (H3N2)

В Хүрээ

Нэмэлтээр тиомерсал, тарилгын шингэн агуулсан.

Савлалт:

Нэг хүн тун нь 0,5 мл, Флаконт 10 хүн тунгаар савлагдсан. Вакцин өнгөгүй шингэн суспенз.

Тун ба тарих арга:

Вакциныг булчинд тарина.

- 3 настай хүүхэд болон түүнээс дээш насныханд 0.5 мл-ээр нэг удаа тарина.

Эсрэг заалт:

- Вакцины найрлагад орсон бодисуудад өмнө нь анафилаксийн урвал илэрч байсан
- Өндөг, тахианы гаралтай бүтээгдэхүүнд хэт мэдрэг хариу урвал өгч байсан
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт өгсөн
- Өмнө нь томуугийн вакцин хийлгэснээс хойш 6 сарын дараа Гиллен Барын хам шинж өгч байсан
- Мэдрэлийн үрэвслийн хам шинжийн үед
- Дархлал дутмагшилтай
- Гормон эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс
- Неомициний төрлийн антибиотикт харшилтай хүн
- Хавдрын эмчилгээний цитостатик эм хэрэглэж буй үед

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын шинжүүд илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд энцефаломиелит, анафилаксийн шок, харшлын урвалууд, татах, мэдрэлийн тогтолцооны ерөнхий болон хэсэг газрын

үрэвсэл, амьсгалахад саадтай болох хүнд урвалууд вакцин хийлгэсний дараа 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдгүүд илэрвэл яаралтай эмчид хандах хэрэгтэй.

Анхааруулга:

- 5) Томуугийн вакциныг бусад товлолын вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна
- 6) Тарилгын стандартыг баримтлан ажиллана
- 7) Задалсан вакциныг дараах нөхцлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
 - Вакциныг +2-+8 хэмд хадгалсан;
 - Вакцины шошго арилаагүй;
 - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- 8) Вакцин хийлгэж байгаа хүмүүст тарьсан хэсгийг бохирдуулахгүй байлгах болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандах талаар зөвлөх хэрэгтэй.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйд вакцин хийхийн өмнө заавал эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсэний 4 дэх сараас томуугийн вакцин хийлгэж болно.

Хадгалах тээвэрлэх:

- Вакциныг +2+8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ.
- Халууны нөлөөнд орсон эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянана.
- Хөлдөөж болохгүй

Үйлдвэрлэгч: Бутантан институт, Бразил



Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 28 өдрийн 1/ тушаалын
гуравдугаар хавсралт

Улирлын томуугийн вакцины мэдээ авах хүснэгт

Хамралтын мэдээг дархлаажуулалтын нэгжүүд өдөр бүр 16:00-21:00 цагийн хооронд нэгтгэн интерактив программд шивж оруулах ба дараа өдрийн өглөө 09:00 цагт аймаг, нийслэл, дүүргийн дархлаажуулалт хариуцсан тархвар судлаач эмч мэдээг хянаж, баталгаажуулан ХӨСҮТ-д илгээнэ. Тухайн өдрийн хамралтын мэдээг нөхөн оруулах боломжгүй тул товлогдсон хугацаанд заавал оруулахыг анхаарна уу. Мэдээтэй холбоотой асууж тодруулах зүйлсийг 99003287 утсаар лавлана.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллага болон бусад байгууллагын ажиллагсдыг томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулсан мэдээ

№	Байгууллагын нэр	Хүлээн авсан нийт вакцин /хүн тун/ Тарисан вакцины /хүн тун/ Хамралтын хувь	Мэргэжлээр			Насны бүлэг				ДДУХ
			Эмч	Сувялагч	Тусгай мэргэжилтэн	16-24	25-49	50-64	≥65	

Мэдээ гаргасан:.....

Хянасан:.....

Улирлын томуугийн вакцин хийлгэхийг зөвшөөрсөн тухай хуудас

Миний хүү/охин овогтой нь настай. дүүргийн
хорооны сургууль, цэцэрлэгт суралцдаг ба улирлын томуугийн вакцин хийлгэхийг зөвшөөрөв.
Улирлын томуугийн эсрэг вакцины зааврыг уншиж, танилцсан болно.
Гарын үсэг: Эцэг/эх
Огноо: 2020 оны сарын өдөр

Тайлбар: Сонгогдсон сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулахаас өмнө энэхүү зөвшөөрлийн хуудсыг ангийн багш хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид заавал танилцуулж, гарын үсэг авсан байна.

Сүүлийн нэг сарын хугацаанд товлолын болон сайн дураар томуугийн вакцинд хамрагдаагүй байх.

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 09 сарын 29 өдрийн 8/тушаалын
дөрөвдүгээр хавсралт 449

6-59 сартай хүүхдэд өндөр тунт А аминдэм түгээх хуваарь

№	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд	6-11 сартай хүүхэд		12-59 сартай хүүхэд	
		Хүүхдийн тоо	100000 ОУН	Хүүхдийн тоо	200000 ОУН
Аймгийн эрүүл мэндийн газар:					
1	Архангай	1521	1521	9310	9310
2	Баян-Өлгий	1575	1575	12600	12600
3	Баянхонгор	1560	1560	8901	8901
4	Булган	843	843	5288	5190
5	Говь-Алтай	829	763	4914	4201
6	Говьсүмбэр	283	186	1839	1748
7	Дархан-Уул	3543	407	16979	2323
8	Дорноговь	1151	1151	8181	8181
9	Дорнод	1252	1052	8311	7441
10	Дундговь	552	552	3923	3923
11	Завхан	1446	780	6016	5000
12	Орхон	2528	207	10882	3000
13	Өвөрхангай	2622	2526	11123	11123
14	Өмнөговь	1510	1510	7192	7192
15	Сүхбаатар	1065	-	8010	-
16	Сэлэнгэ	2629	2629	11295	11295
17	Төв	1849	1849	10233	8914
18	Увс	1266	469	8836	6336
19	Ховд	1400	1400	11100	10000
20	Хөвсгөл	2010	1615	15952	15952
21	Хэнтий	1239	1239	7698	7484
Дэд дүн		32673	23834	188583	150114
Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага:					
1	Багануур дүүрэг	670	618	2562	2398
2	Багахангай дүүрэг	116	97	417	393
3	Баянгол дүүрэг	5439	5304	24050	22837
4	Баянзүрх дүүрэг	8445	8445	36365	36365
5	Налайх дүүрэг	851	840	3546	3497
6	Сонгинохайрхан дүүрэг	7812	7812	33591	33591
7	Сүхбаатар дүүрэг	3168	2919	13910	13279
8	Хан-Уул дүүрэг	4585	4585	20443	20443
9	Чингэлтэй дүүрэг	3630	3408	15160	14226
10	Асрамж, халамжийн төв (НЭМГ)	1000	1000	1000	1000
11	НЭМҮТ /нөөц/		1000		1000
Дэд дүн		37716	37028	153044	150029
Нийт дүн		70389	60862	341627	300143

Тайлбар: Хэрэв 6-11 сартай хүүхдэд 200 000* ОУН тунтай А аминдэмийг ЭМС-ын 2013 оны 470 дугаар тушаалын дагуу ½ капсул (3 дусал)-ыг 100 000 ОУН-ээр тооцон уулгана.